



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох, үе шаттай нэмэгдүүлэх хуваарь батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 2,500,000,000 /хоёр тэрбум таван зуун сая/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 600,000,000 /зургаан зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан шинээр эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 300,000,000 /гурван зуун сая/ төгрөг, аймаг сумдад 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

3. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарийг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг нэмж олгохдоо энэхүү тогтоолын 1-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан банк бус санхүүгийн байгууллагад олгосугай.

5. Энэ тогтоол нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 271, 2017 оны 27 дугаар тогтоолууд тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 201...оны  
... дугаар тогтоолын хавсралт

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

/сая төгрөгөөр/

| Огноо      | Улаанбаатар хот | Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад | Бусад аймаг, сумдад |
|------------|-----------------|--|---------------------|
| 2020.02.10 | 1,900.0         | 475.0  | 145.0               |
| 2021.02.10 | 2,500.0         | 600.0  | 200.0               |

Санхүүгийн зохицуулах хорооны 201...оны  
... дугаар тогтоолын хавсралт

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААГ ДАГНАН ЭРХЭЛЖ БУЙ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

/сая төгрөгөөр/

| Огноо      | Улаанбаатар хот | Бусад аймаг, сумдад |
|------------|-----------------|---------------------|
| 2020.02.10 | 200.0           | 100.0               |
| 2021.02.10 | 300.0           | 200.0               |

